



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор
Л.Жаргалсайхан
Утас: 70272582
И-мэйл:
jargalsaihan_tuv@yahoo.com

Аудитор Ц.Саранчимэг
Утас: 70273204
И-мэйл:
Tsaranchimeg@yahoo.com

• Танилцуулга	3
• Санхүүгийн дотоод хяналт	3
• Гол шийдлүүд	5
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	6
• Аудитын санал дүгнэлт	6

Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон

Аймгийн Халамжийн сангийн 2013 оны Санхүүгийн тайланд ААГ-аас аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид Нийгмийн халамжийн сангийн 2013 оны Санхүүгийн тайланд аудит хийж дуусган Аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дууссан тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар эдгээр санхүүгийн тайлангуудыг дахин шалган нягтлахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулвал:**
- Орлого санхүүжилт, нийгмийн халамж болон хүн амын хөгжлийг дэмжих сангуудын хувиарлалт, олголт, зарцуулалт, буцаалт бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн болно.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг торуулбал:

1. Хараагүй хүний тусгай хэрэгслийн 3420.0 мянган төгрөгийг MGLAT ХХК-д шилжүүлсэн боловч тусгай хэрэгсэлийг аваагүй, иргэдэд олгоогүй байхад дансанд авлагаар бүртгэж тусгалгүй олгосноор тайлагнасан байна.
2. Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын I хавсралтын 6.3-ийг зөрчин бэлэн мөнгө гаргахдаа нэг удаагийн гаргалтаар 6157.8 мянган төгрөгийн томилолт, унааны мөнгийг бэлнээр гаргасан байна.
3. НХҮЕГазрын ажилтнуудын албан томилолтоор ирж ажилласан хугацааны буудалд байрласан байрны зардал болох 550.0 мянган төгрөгийг өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны зардлаас олгож төсвийг үргүй зарцуулсан байна.
4. Удамт Жонон ХХК-нд Өндөр ширээт сумын 22 өндөр настанг 10 хоног амруулсан гэж баримт бүрдүүлэн 3300.0 мянган төгрөг

мөн Борнуур сумын 7 өндөр настан 10 хоног амарсан гэж нийт 4350.0 мянган төгрөг олгосныг шалгахад 3 шөнө 1 өдөр байрласан ба илүү 6 хоногийн мөнгө 2340.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

5. Нэхэмжлэлээр олгож буй халамжийн үйлчилгээнд дотоод хяналт сул байгаагаас чанаргүй, үргүй зардал гарч байна.

ЕМ, Санхүүгийн албаны даргаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа.

Ерөнхий Аудитор 2014.02.05 -ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна. Эцэст нь аудитын явцад хамтран ажилласан та бүхэнд гүнээ талархаж байна.

Төв Аймгийн Аудитын Газар.
2014.02.05

Танилцуулга

1. Бид Халамжийн сангийн 2013 оны Санхүүгийн тайланд аудит хийж дуусган Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дууссан тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар эдгээр санхүүгийн тайлангуудыг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Халамжийн сангийн хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй, материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн даргад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.
4. Дээд түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн удирдлагын анхаарлыг хандуулж байна.

I. Дотоод хяналт шалгалтын талаар:

Дотоод хяналтаар алдаа зөрчлийг илрүүлэн засаж сайжруулах талаар тодохой ажил зохиож ажилласан байна. Үүнд халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламж, жирэмсэн амаржсан, нярай хөхүүл хүүхэдтэй эхэд олгох тэтгэмж, алдарт эхийн одонтой, алдар цолтой ахмадад, ахмад настны нийгмийн хамгаалалын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж, ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож буй хөнгөлт тусламжийг үзүүлэхэд сар бүр хяналт тавьж ажилласан байна.

Мөн зайны хяналтаар хөнгөлөлт тусламжийн 1898 материал, тэтгэвэр тэтгэмжийн 3582 материал хяналт шалгалт хийсэн байна. Тус хяналт шалгалтаар хөнгөлөлт тусламжаас 134, тэтгэвэр тэтгэмжээс 148 зөрчил илэрсэн байна. Энэ нь нийт хянагдсан материалын 5 хувийг эзэлсэн дүнтэй гарсан байна. Дотоод хяналт шалгалтаар алдаа зөрчлийг илрүүлж ажилласан боловч нэхэмжлэлийн дагуу олгогдож буй халамжийн нэг удаагийн хөнгөлөлтөнд тавигдах дотоодын хяналт шалгалт хангалтгүй энэ талаар тодорхой хийсэн ажил байхгүй байна.

II. Орлого санхүүжилтийн талаар:

Төсвийн сар, улирлын хуваарийг үзэж, энэ хуваарийн дагуу санхүүжилтээ авсан эсэхийг шалгахад 2013 онд орон нутгийн төсвөөс халамжийн тэтгэвэр, тэтгэмж, олон

нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж, ахмад настанд үзүүлсэн тэтгэмж тусламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхэд олгох тэтгэмж, хүнс тэжээл нийгмийн халамжийн хөтөлбөр, банкны шимтгэл, АДЗөвлөлийн гишүүдэд олгох урамшуулал зэрэг халамжийн үйлчилгээнд нийт 7057.2 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөгдсөнөөс Аймгийн ИТХурлын тогтоолоор 200.0 сая төгрөгөөр бууруулан 6857.2 сая төгрөгөөр батласан байна. Улсын төсвөөс алдар цолтой ахмад настанд үзүүлсэн тусламж, алдарт эхийн одонгийн мөнгө, судалгааны ажилд 1662.4 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөгдсөн байна. Улсын төсвөөс 1662.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 6857.2 сая төгрөг нийт 8519.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 7218.3 сая төгрөгийн санхүүжилт авч төлөвлөгдсөнөөс 1300.8 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна. Төлөвлөгдсөнөөс дутуу авсан санхүүжилтийг тодруулбал халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжаас 870.2 сая төгрөг, хүнс тэжээл нийгмийн халамжийн хөтөлбөрөөс 285.2 сая төгрөг, жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхэд олгох тэтгэмж 137,8 сая төгрөг, ОНО түшиглэсэн халамжийн үйлчилгээ 33,6 сая төгрөг, алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж 24,0 сая төгрөгөөр тус тус дутуу санхүүжигдэж, алдарт эхийн одонгийн мөнгө 50,0 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс илүү санхүүжилт авсан байна.

Жирэмсэн хөхүүл эхчүүдийн мөнгөн тэтгэмж, алдарт эхийн одонгийн мөнгөн тусоамж, алдар цолтой ахмадуудын хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийн үйлчилгээ, хүнс тэжээлийн үйлчилгээнд нийт 7218,3 сая төгрөгийн орлого, үйлчилгээний орлогоор хүүгийн орлого, маягтын орлого, буцаасан орлого 30.5 сая төгрөг нийт 7248.8 сая төгрөг орлого санхүүжилтийг бүрэн тусгасан байна.

Төлөвлөгдөөгүй орлогоор сангийн чөлөөт үлдэгдэлд хүү тооцож 8.2 сая төгрөг, маягтын орлого 0.2 сая төгрөг, бусад эх үүсвэр 22.1 сая төгрөгийн нийт 30.5 сая төгрөгийн орлого оруулсан байна.

III. Харилцах болон бэлэн мөнгөний зарцуулалтын талаар:

Халамжийн сангийн нэгдсэн тайлан дах мөнгөн хөрөнгийн үлдэгдэлийг шалгахад 160236,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсаныг банкны үлдэгдэлийн баталгаатай тулган шалгалаа. Үүнд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлийг хүснэгтээр харуулав.

№	Банкны нэр	Дансны дугаар	Халамжийн төрөл	Мөнгөн дүн
1	Хаан банк	5721332384	Нэг удаагийн хөнгөлөлт	31831803.02
2	Хаан банк	5721332464	Жирэмсэн болон нярай хүүхэдтэй эх	54605197.16
3	Төрийн банк	31000005948	Халамж тэтгэвэр, тэтгэмж	73799091.11
	Дүн			160236091.29

Харилцах дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэлийг үнэн зөв тайлагнасан байна.

Халамжийн тэтгэвэр тэтгэмж тусламж хөнгөлөлтөөр 2013 онд 8519.1 сая төгрөгийн үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 6976.8 сая төгрөгийг зарцуулж төлөвлөгдсөнөөс 1542.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна. Энэ нь санхүүжилтийн эх үүсвэр 1300.7 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэнтэй холбоотой ба үүнийг хасч тооцвол тайлант оны санхүүжилтээс 241.5 сая төгрөг хэмнэгдсэн байна. Халамжийн сангийн зарцуулалтыг шалгахад дараах зөрчлүүд гарсан байна.

- ✓ Хараагүй хүний тусгай хэрэгсэлийн 3420.0 мянган төгрөгийг MGLAT ХХК –д шилжүүлсэн боловч тусгай хэрэгслийг иргэдэд олгоогүй байна.
- ✓ Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын I хавсралтын 6.3.Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон **банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх** ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ-500,000(таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна гэснийг зөрчин бэлэн мөнгө гаргахдаа нэг удаагийн гаргалтаар 6157.8 мянган төгрөгийн томилолт, унааны мөнгийг бэлнээр гаргасан байна.
- ✓ Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын ажилтнуудын албан томилолтоор ирж ажилласан хугацааны буудалд байрласан байрны зардал болох 550.0 мянган төгрөгийг өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны зардлаас олгож төсвийг үргүй зарцуулсан байна.
- ✓ Удамт Жонон ХХК-ны Өндөр ширээт сумын ахмад 22 өндөр настанг 10 хоног амруулсан гэж баримт бүрдүүлэн 3300,0 мянган төгрөгийг авсан байгааг амралтанд амарсан өндөр настнуудаас тодорлуулахад 3 шөнө 1 өдөр л болсон 10 хоног амралтын газар байгаагүй гэж мөн Борнуур сумын 7 өндөр настан 3 хоног амарснаас үзэхэд 6 хоногийн мөнгө нийт $1920,0 + 420,0 = 2340,0$ мянган төгрөгийг илүү олгосон байна. Иймд нэхэмжлэлээр гарч халамжийн үйлчилгээнд дотоод хяналт сул байгаагаас чанаргүй, үргүй зардал гарч байна.

IV. Өр авлагын талаар:

Өр авлагыг үнэн зөв бодитой бүртгэснийг шалгахад санхүүгийн тайланд олгоогдоогүй тэтгэмжинд 160236,1 мянган төгрөгийг өглөгөөр тусгасан байна. Энэ нь нэг удаагийн хөнгөлөлт тусламж 31831.8 мянган төгрөг, халамжийн тэтгэвэр тэтгэмж 73799.0 мянган төгрөг, жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхэд олгох мөнгөн тэтгэмж 54605.2 мянган төгрөг нийт 160236,1 мянган төгрөгийн олгоогдоогүй мөнгийг олголтын жагсаалт болон файлаар өглөгийг үнэн зөв бүртгэж тайлагнасан байна.

Авлагын хувьд Хараагүй хүний тусгай хэрэгсэлийн 3420.0 мянган төгрөгийг MGLAT ХХК –д шилжүүлсэн боловч тусгай хэрэгслийг иргэдэд олгоогүй байгааг авлагаар бүртгэж тайлагнаагүй зөрчил илэрлээ.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 4 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- ✓ 3420.0 мянган төгрөгийн тусгай хэрэгсэлийг авч хараагүй иргэдэд олгуулахаар албан шаардлага өгөх
- ✓ 2340.0 мянган төгрөгийг илүү авсан өндөр настны амралтын мөнгийг төлүүлэхээр төлбөрийг акт тавих
- ✓ 550.0 мянган төгрөгийн дээд газрын албан томилолтоор ирж ажилласан ажилтнуудын буудлын хөлсийг төлүүлэхээр төлбөрийн акт тавих

6. Эдгээр асуудлуудыг ААГ болон Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод

хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж

Өмнөх онд Санхүүгийн тайлангийн аудитаас дараах зөвлөмжийг өгсөн байна.

1. Нийгмийн халамжийн сангийн тайланг бэлтгэж тайлагнахдаа холбогдох заавар журмыг үндэслэн сангийн бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөх
2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг аж ахуй нэгж, байгууллагын удирдлага хүлээнэ.” Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах үүнд олгогдоогүй тэтгэмжийн үлдэгдлийг халамжийн төрөл бүлгээр болон овог нэр, регистрийн дугаараар оруулан баталгаажуулж санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнах мөн төрийн сан болон арилжааны банкуудаар дансны үлдэгдлийн баталгааг гаргуулахдаа үнэн зөв гаргуулах тал дээр анхаарч ажиллах.
3. Төрийн сангаас гаргаж байгаа ахмад настанд үзүүлэх 1 удаагийн хөнгөлөлт үйлчилгээ тусламж болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний олголтыг хийхдээ халамжийн сангийн программд овог нэрээр регистрийн дугаараар нь оруулж байх
4. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг мөрдөж, сургалт зохион байгуулахдаа тухайн орон нутгаас албан томилолттой ирүүлж , томилолтын тооцоог холбогдох журмын дагуу хийж байх

Зөвлөмжийн дагуу дараах ажил хийгдэж зөвлөмжийн хэрэгжүүлж ажилласан байна.

1. Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газраас НББ-ийг сайжруулах сургалтанд хамрагдаж, энэхүү газраас ажлын хэсэг гарч НБББББичгийг боловсруулах шатандаа явагдаж байна.
2. Тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлт тусламжийг төрөл тус бүрээр олгогдоогүй мөнгөний зарцуулалтыг гаргаж тайлагнасан.
3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн мэдээллийг сангийн программд овог нэр регистрээр оруулсан.
4. Банкуудтай хийсэн гэрээнд хяналт тавьж, хүүний дутуу төлөлтийг нөхөн оруулсан.

Эрсдэлийн аудитаар 2013 онд дараах зөвлөмжийг өгсөн байна.

1. ХААН банкт байгуулсан **Нийгмийн халамжийн зарим үйлчилгээг арилжааны банкаар дамжуулан иргэдэд олгох тухай гэрээ-ний** 6.1-д заасан заалтыг мөрдөж олголтын хаалтын файлыг баталгаажуулсан жагсаалтаас зөрүүтэй байгаа зөрчлийг давтан гаргахгүй байх
2. Банкны ажилтны буруугаас болж халамжийн үйлчилгээг зохих данснаас гаргахгүй өөр данснаас гаргах , буруу хийгдсэн гүйлгээг залруулан данс хооронд санхүүжилт гаргаж залруулах гүйлгээг хийдэг явдлыг гаргахгүй байх талаар ХААН банкт байгуулсан гэрээний 5.2-д НХҮХэлтсээс ирүүлсэн нэрийн жагсаалт болон файл өгөгдөөгүй тохиолдолд сангийн данснаас зарлага урьдчилан олгохгүй байх гэсэн заалтыг мөрдөж ажиллах
3. Арилжааны банкаар дамжуулан олгосон халамжийн сангийн зарцуулалтыг олголтын жагсаалттай IDEA программаар шалгах учир харьяалалгүй ахмад настанд хүндэтгэл үзүүлсэн үйлчилгээ болон хүнс тэжээл хөтөлбөрийн дансны зардлын олголтын овог нэр, регистрийн дугаар, олгосон мөнгөн дүнтэй жагсаалт файлаар бэлтгэж өгөх

Эрсдэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу дараах ажил хийгдэж зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар ажил зохиож эхэлсэн байна.

1. Нийгмийн халамжийн сангийн 9.10.11.12 сарын олголтын файл хаалтын файл тус бүр дээр банкны нягтлан бодогчтой тооцоо нийлж баталгаажуулж ажилласан.
2. Халамжийн сангийн үйлчилгээг арилжааны банкуудаар гүйцэтгүүлэх талаар байгуулсан гэрээндээ банкны ажилчидтай хамтарсан дотоод хяналтыг улирал бүр хийж хариуцлагагүй ажиллаж алдаатай гүйлгээ хийсэн ажилтантай хариуцлага тооцож ажиллахаар нэмэлт заалт оруулсан.
3. Нийгмийн халамжийн сангаас харьяалалгүй ахмад настанд зкззлэх хөнгөлөлт тусламжийг ХҮМ программд шивж файл болгон олгосон.

Тайлбар мэдүүлгийн захидал

7 Аудитын үйл явцад ААГазрын аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

8.Аймгийн Аудитын газраас тус Нийгмийн халамжийн сангийн санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар
2014.02.05.